

## ДАЦАНГИЙН НОМ ЗОХИОЛУУД

*Ш.Б.Чимитдоржиев\**

Унгарын монголч эрдэмтэн Дьердь Кара /Хардорж-орч./ :”Монгол, буриад, халимагууд нүүдэлчин өвөг дээдсийнхээ бичиг соёлын баялагаар бахархах нь зүй ёсны хэрэг билээ...Монгол ард түмний бичгийн соёл 13-р зуунд бий болсон юм.” /1/

XIII-р зуунд монголын нүүдэлчид уйгар-монголын босоо бичиг хэмээн өөрийн бичиг үсэгтэй болсон юм. Эдүгээ хуучин монгол / сонгодог/ хэмээн нэрлэж буй энэхүү бичгээ хэрэглэн бичгийн зохиолоо туурвиж эхэлсэн. Эрдэмтдийн хийсэн судалгааны ачаар эртний монгол бичгийн дурсгалууд тодорхой болжээ. Сүм хийдүүдийг татвараас чөлөөлөх хааны зарлиг, XIII-XIV-р зууны зааг үеийн монгол-францын харилцааны тухай захидалууд болон цэрэг дайчдын эр зоригыг магтан дуулсан шүлэгүүд, уянгын дууны цоморлиг, домог яриа уламжлагдан ирсэн байна. Үүний дотор буддын шашны зохиол, шашин-гүн ухааны шастирууд ч бий. XIII-р зууны түүх-утга зохиолын гарамгай бүтээлүүдийн нэг “Монголын нууц товчоо” бол нийт монголчуудын дурсгалт бичиг мөн. Эртний монгол хэлтэн ард түмнүүдийн умардын Байгаль нуур орчмын буриадууд эдгээр эртний бичгийн дурсгалуудыг бусад монголчуудтай адил тэгш өөрийн үндэсний уран зохиол, соёлын өв гэж үзэх эрхтэй билээ.

Эртний үеэс буриадын хорь, түмэд, баргууд, их эрэс, булагат аймгууд монгол овог аймгууд Төв Азийн соёл иргэншилд үндэс сууриа тавьсан нэгдмэл соёл, нэгдмэл бичиг үсэгтэй байсан. Эртний ба дундад зууны Буриадын түүх нь Монголын хийгээд монгол угсаатны түүхийн салшгүй нэгэн хэсэг мөн. Буриадуудын газар нутаг XVII-р зууны эцэс хүртэл Байгаль нуурын хавь, эртний нэрээрээ Баргужин-Тукум нь монгол угсаатны бүрэлдэхүүнд байсан. Хуучин монгол бичиг нь монгол угсаатны нийтийн соёлын өв юм. Олон зуун жилийн турш энэ бичиг овог аймгуудыг холбох чухал хүчин зүйл харилцан ойлголцлын түлхүүр болж байлаа. Энэ бичгээр хэвлэгдсэн номууд олон аялгаар ярьдаг Монголын аль ч омог, аймагт ойлгомжтой байсан нь гайхалтай. Уйгаржин бичгээр түүхэн он дарааллын бичиг, ардын аман ба уран зохиолын бүтээл, дээд зиндааны иргэний болон шашны зохиолууд туурвижээ. 16-р зуунаас бурхны шашин Монголд өргөн дэлгэрсэнээр

\*Ш.Б.Чимитдоржиев - доктор (Sc.D), профессор, Монгол Улсын ШУА-ийн “Хүндэт доктор” (ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбар)

буддын шашны ном зохиол ихээр гарах болов./2/ Эдгээр номууд монгол, төвд хэлээр хэвлэгдэн тархжээ. Өнгөрсөнд буриадын ард түмэн баялаг, олон төрөлт утга зохиолтой байв.

Энэ өгүүлэлд Зөвлөлтийн үед Буриадын дацангуудад хадгалагдаж байсан номуудын тухай товч өгүүлэх зорилго тавьсан юм./3 /

Буриадад анх байгуулагдсан дацангууд буддын шашин, гүн ухааны төвүүдийн үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд дэргэдээ ихээхэн ном судартай номын сантай байсан аж. Мөн дээд зиндааны төдийгүй жирийн лам нар хүртэл хувийн номын сантай байжээ. Зөвхөн буддын шашинтай холбоотой номуудаас гадна, уран зохиол, түүхийн талын багагүй ном зохиол цуглуулсан байна.

Харамсалтай нь бид энд өнгөрсөн зуунуудад Буриадын дацангийн номуудын тухай бүрэн дүүрэн мэдээлэл алга. Зөвхөн 30-аад оны лам нарын хэлмэгдүүлэлт, дацангуудыг устгаж байсан үеийн хэсэг бусад мэдээлэл /архивын ба гар бичмэл/ дээр тулгуурлаж, дацангийн номууд, тэдгээрийн нийт тоо, агуулгын тухай зарим төсөөлөл авч болох юм.

“Агван Доржиевын амьдралын хуудсууд” /Улаан-Үд, 1993/ хэмээх номонд 30-аад онд Буриадын дацангуудад байсан буриад, монгол, төвд хэл дээрх номуудын тухай Буриадын Үндэсний архивын фонд, Буриад-Монголын АССР-ын Төвийн Гүйцэтгэх Хорооны илтгэл Шашингүйн музейн материал, 30-аад оны үед тус БНУ-д утга зохиолын дурсгалуудыг зэрлэгээр устгасан тухай А.Доржиевын мэдэгдэл зэргийг багтаажээ. /4/ Архивын мэдээгээр, 1934 онд үйл ажиллагаагаа явуулж буй 27 дацан 150 мянган ном зохиолтой байсан байна. Харин тэр үед устгасан 20 дацанд тэдгээрээс дацан бүрд дунджаар 5 мянган номтой байжээ. Жишээлбэл, Агийн дацангийн номын санд 15 мянган боть ном байсан. Лам нарын хувийн номын сангийн тухайд гэвэл, 19-20-р зууны заагт амьдарч байсан бандида хамба лам Чойнзон-Дорж Ерөөлтуевийн номын санд 1000 гаруй боть номтой байжээ. /5 /

Дацангийн номуудыг дараахи байдлаар ангилж болно:

1. Энэтхэгийн буддын шашны номуудын орчуулга /самгарьд хэлнээс төвд, монгол хэлнээ хөрвүүлсэн/ бөгөөд голдуу Монгол, Төвд, Хятад ба зарим хэсэг нь Буриадад ксилограф аргаар хэвлэгдсэн номууд, тэдгээрийн гар бичмэлүүд. /Буриадад дахин хэвлэгдсэн/

2. “Гэлүгба” /шар малгайтны/ урсгалын Төвдөөс авчирсан Төвд, Монголын буддын шашны түүхийн асуудлууд болон Ганжуур, Данжуурын зарим тэдгээрийн тайлбар бүхий буддын шашны номууд. Эдгээр номууд Төвд, Монгол, Хятад, Буриадад хэвлэгдсэн байв.
3. “Гармаба” /улаан малгайтны/ урсгалын ном зохиолууд бөгөөд зөвхөн Төвдөд цөөхөн тоогоор хэвлэгдсэн онцлогтой байв. Энэ урсгал нь монгол угсаатан, түүний дотор Буриадад тэрс үзэлтний гэж тооцогддог байсан. Иймээс Буриадын дацангуудад энэ урсгалын ном зохиол олон талаар хадгалагдан үлджээ. Буддизм дэлгэрч байсан үед эдгээрийг Буриадад гаднаас оруулж иржээ.
4. Орос болон баруун Европ хэл дээр бичсэн цөөн тооны ном зохиолууд.
5. Уйгаржин монгол бичгээр бичсэн шашин-гүн ухааны ном судрууд. Үүнд: буддын шашны түүх, сүмбүм, уншлагын ном, субашидууд-буддын шашны ёс суртахууны дүрмүүд, гүн ухаан, одон орон, монгол, буриад шашны томоохон зүгэлтэнүүд болон зарим ноёдын бичсэн анагаах ухааны зохиолууд, гол төлөв баатар эрс, ид шидтэний тухай уран зохиол ба түүхийн номууд г.м.

Буриад дацангуудын ном зохиолуудын дийлэнх нь мэдлэгийн янз бүрийн салбарт ойлгоход туслахуйц төвд, монгол, буриад зохиогчдын тайлбарууд нь мэдлэгийн бүхий л салбарыг ойлгох гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Жишээлбэл, санскрит хэлнээс орчуулсан анагаах ухааны гол судар хэмээх “Жүд-ши”-гээс гадна, 100 гаруй анагаах ухааны ном, тайлбар бичгүүд байсан байна./ тус бүр 10-1000 хуудастай/

Үүнээс гадна, “Монголын хөх номууд” гол төлөв цэнхэр буюу заримдаа шар өнгөтэй цаасан дээр бичсэн эртний зохиолууд бий. Эдгээр зохиолд янз бүрийн домог, яриа, Буриадын бөөгийн шашны мөргөлийн газруудад тусгайлан зориулж зохиосон уншлагууд багтана. /Ольхон аралын эзэнд, Түнхэн аймгийн Буха-ноён уулын эзэнд г.м./ Ийм номууд ихэнхдээ лам буюу язгууртны хувийн номын санд хадгалагддаг байв.

Дацангийн номуудын олонхи нь, ялангуяа, Төвд, Монголоос авчирсан номууд, буддын шашны гол сударууд маш үнэтэй байсан. Тухайлбал, 1871 онд Агийн дацан Монголын нэгэн хийдээс 235 боть монгол Ганжуур, төвд /нартан/ Данжуурыг 700 адуугаар худалдан

авчээ. 1835 онд Гүнийн дацан 100 боть Ганжуурыг 30 эр үхэр, 100 адуу, 30 хониор авсан. 1884 онд Төвдөөс Агийн дацан руу Ганжуурын 1 ботийг 15 рублээр худалдан авчээ. /нийтдээ тэр үеийн ханшаар 1650 рубль/ 1913 онд хамба лам Ерөөлтуев Зонхавын зохиолын 45 ботийн боть тус бүрийг 12 рублээр худалдан авсан байна. Үүнээс үзэхэд, тус зохиолын боть /дунджаар 400 хуудас/ болгоныг ксилограф хэвлэлийн зардал нь 10 алтан рублээс доошгүй болж байсан байна.

Зарим дацангуудад ердийн бүтээлүүдээс гадна, тусгай зориулалтын хар цаасан дээр “9 эрдэнээр” /алт, мөнгө, зэс, төмөр, шүр, сувд, оюу, тана, номин/ бичсэн онцгой үнэтэй номууд байсан байна. Жишээлбэл, Түнхэн аймгийн төвийн Кырений дацан болон Сэлэнгийн зарим дацангуудад “9 эрдэнээр” бичсэн Ганжуурууд байв. Түнхэний Ганжуурын хуудас болгон 1909 оны ханшаар 1 рубль 15 копейкийн үнэтэй байв. Боть болгон нь 500-аас доошгүй хуудастай 108 боть байсан гэж бодвол Ганжуур нь 63250 рублийн үнэтэй байжээ. Ном болгоны хоёр талын гаднах бүрээс 10 рубль гэж тооцоход, 1100 рубль болж байна. Боть болгон нь 3 давхар 1 метрийн хэмжээтэй хятад торгон баринтагтай бөгөөд 1 метр торго 650 рублийн үнэтэй байсан байна. Цаас, будагны зардалыг тооцохгүйгээр, нийт дүн 65000 рубль болж байна.

Ацагатын /Чулуутаевын/ дацанд мөнгөөр чимж бичсэн Ганжуурыг Агван Доржиев Төвдөөс Далай ламын бэлэг гэж авчирсан аж. А.Доржиев, Г.Цыбиков, Б.Барадин зэрэг Буриадын шашны төлөөлөгч, бадарчин, жуулчид Дорнын утга зохиолын дурсгалыг цуглуулсан их гавьяатай билээ. Хамба лам Ерөөлтуев өнгөрсөн зууны 90-ээд оны эцэст Энэтхэгээр аялж, Шанхайгаар дамжин буцах замдаа буддын шашин тархсан Хятадын баруун нутгаар очих зорилготой байв. Гэвч Шанхайд байхдаа Бээжинд суугаа Оросын төлөөлөгч буриад Найдан Гомбоевоос орос цэргүүд хааны ордныг барьцаанд авсан тухай цахилгаан мэдээ авч, даруйхан Бээжин зорив. Тэр буддын шашны үнэтэй гэсэн номуудыг шилж аваад, тэмээн жингээр Орос явуулсан. Тэр номуудын дунд монгол хэлээр бичсэн Ганжуур, Данжуурын бүх ботиуд байсан байна. Ганжуурыг Чисаны дацангийн ширээт Эрдынеевт 1 ботийг 25 алтан рублээр, Данжуурыг Хальмагийн ван Тундутов ордонхоо хуралд, Халимагийн хамба лам Барманжинов авсан байна. Барманжинов Ерөөлтуевын аялалд зориулж 15000 рубль өгсөн байна.

Эрт дээр үеэс буриад-монголчууд эрдэм боловсролтой хүнийг хүндэтгэж, буддын шашны ном төдийгүй бичгийн дурсгалт зүйлүүдээ хадгалахыг хичээдэг байсан. Эдгээр нь ганц номын сургаал биш, сахиусны бэлэг дэмбэрэлтэй байжээ. Иймээс шашны ном судрыг сүсэгтэн олон их шүтэж, үл хүндлэх байдал нүгэлд тооцогддог байв. /6/

Буриадад ксилограф, гар бичмэл бүтээлүүдийн аль алин ч түгээмэл байжээ. Эрт дээр үеэс дундад зууны үед буриадууд монгол угсаатны бүрэлдхүүн хэсэг байсан бөгөөд Монголын нэгдсэн төр засагт хамаарч, бүх монгол туургатны адил ном хэвлэлийн нэгдмэл түүхтэй байсан нь эргэлзээгүй.

Эртний үеийн бичгийн дурсгалт зүйл, дундад зууны үеийн эрдэм мэдлэгийн янз бүрийн салбарын, юуны түрүүнд, буддын шашны зарим бүтээлүүд уламжлагдсаар ирсэн билээ.

Эдгээр нь Буриадад дацан хийдүүдийг хааж, зэрлэг бүдүүлгээр номуудыг устгахаас өмнө хадгалагдаж байжээ. Одоо эдгээр соёлын өвийн зарим хэсгүүд Улаан-Үд, Улаанбаатар, Санкт-Петербург, Бээжин, Парис, Киото, Копенгагены гар бичмэлийн сан, архивт бий.

Хэвлэлийн үйлдвэр Буриадад хэзээ бий болсон тодорхой мэдээ одоогоор алга. Ер нь буриадууд бусад монгол угсаатны адил угийн бичгээ зохиодог байсан нь гарцаагүй. Эдгээр нь бичгээр үйлдэж, гар бичмэл нь дараагаар хүмүүсийн гараар дамждаг байсан. Буриадад ном хэвлэл бий болсон үеийг буддын шашин дэлгэрсэнтэй холбох нь зүйтэй болов уу.

XVI-XVII зуунд дацангууд дэргэдээ туслах үүрэг гүйцэтгэж байсан албануудтай байв. Дацангийн литографид шашин-гүн ухааны, ардын аман ба уран зохиол, түүх, үйл явдлын товчоон зэрэг зохиолууд XVII-XVIII зуунд хэвлэгдэж байсан тухай бодитой мэдээлэл бий. Буддын шашин дэлгэрэх явцад монгол бичиг дээр шашны номууд бий болсонтой холбоотой. Мөн өөр төрлийн зохиолууд ч бий болсон. Үүнийг “Талын цааз”-ны ба XIX-зууны эхэн хагаст аялсан Английн шашны номлогчдийн баримт мэдээ нотолж байна.

XIX зуунд Буриадын бараг бүх дацангууд шашны ном зохиол хэвлэдэг байсан. 1887 онд хамба лам Дампил Гомбоев Оросын ван Ухтомский-д гардуулсан номын жагсаалтаар үйл ажиллагаагаа явуулж буй 34 дацангуудын 29 нь литографтай байжээ. 1887 онд монгол, төвд хэл дээр 600 ном хэвлэгдэн гарсанаас Цугольский дацанд-169, Галууг нуурын-97, Зэдийн-52, Эгэтуйн-44, Чисаны-30 нь г.м. /7 /

Агийн дацангийн литографи нь тэр үед нэртэй байсан бөгөөд тусгай байранд байсан байна. Төмөр хайрцаганд төвд, монгол хэл дээр бичсэн 47 525 ширхэг жилийн хэвлэх модон барууд бөгөөд шашны сэдэвтэй холбоотой 592 зурагтай байв. 1923 оны 2-р сарын 23-ны өдөр бичсэн дацангийн ширээт Самдан Сэдэбүний захиа тус дацангийн хэвлэлийн тухай сүүлчийн нотолгоо юм шиг байна. Уг захидалд гавж лам Лодон Болодуны удирдлагаар ном хэвлэдэг, хэвлэсэн номуудын жагсаалт байсан тухай дурьджээ. 1922 онд 8044 хуудас хэвлэж, хэвлэлийн шинэ модон баруудыг бэлтгэсэн байна. Гавж Сэвзэн Дорж эмийн тухай 140 хуудастай ном, Жалсан Бадма-"Их Ламрим", Дондүб Дугар "Даяг Ченпо"-гийн хэвлэхээр бэлтгэж, Сэрэн Пагма "Дэлбэ Шибран"-гийн 830 хуудас хэвлэлд бэлтгэжээ./8 /

Буриалдын 47 дацаны дөрвөнийх нь номын жагсаалт, нийт 1696 боть бидний үед хүрч иржээ. Эдгээр дацанд дорнодын уламжлалт анагаах ухааны оточ лам нар бас ажиллаж байв. Ацагатын ба Цугольский дацангийн маарамба нар их нэртэй байв. 1926 онд Төвдөөс Цугольский дацанд "Анагаах ухааны атлас" авчирч, дараа нь Ацагатын дацанд шилжүүлжээ.

1917 оны Октябрийн хувьсгалын дараа бурхан шүтлэггүй хүмүүс засгийн эрхэнд гарч, шашин сүм хийдийн эсрэг аян эхэлсэн юм. 20-оод оноос дацан хийдүүдийг хааж, лам нарыг хэлмэгдүүлсэн түүхийн "хар" хуудас эхэлсэн билээ. 1923 онд Буриад-Монголын АССР-ийн нутаг дээр /сүүлд тусгаарласан Агийн ба Эхирит-Булагатын хоёр тойрог оролцуулан/ 44 дацан, 1935 онд - 27 дацан үйл ажиллагаагаа явуулж байв. Дараахи жилүүдэд бүх дацанг хааж, мянга мянган лам нарыг устгасан явдал гарсан юм. 1934 онд А.Доржиевын Зөвлөлтийн Төвийн Гүйцэтгэх хорооны эвлэлд хандаж бичснээр: "30-аад онуудад уран зохиолын дурсгалт бичгүүд зэрлэгээр устгаж, тамхины цаас болгон хэрэглэж байна" гэжээ. /9/ Мөн хэвлэх төхөөрөмжөөс гадна, энэтхэг-төвд, монгол-буриад гаралтай үнэт эмүүдийг устгаж байсан шашингүйн үзэлтнүүдийн өгсөн тушаалын дагуу бурхан, номуудыг устгасан. Жишээлбэл, 1934 онд Цолгийн дацанг хаахад Ганжуур, Данжуураас гаднах баринтагийг авч, доторх номуудыг нь хог дээр хаясан байна. Төрийн байгууллагуудад байсан ном, зохиолууд ч мөн ялгаагүй. 1930 онд Алаарын дацангаас Соёлын хүрээлэнд авчирсан Ганжуурыг БНУ-ын орон нутгийн хадгалж байсаныг, 1932-1933 онд музейн байрыг өөр байгууллагад шилжүүлэх үед устгасан байна.

1927 оноос Соёлын хүрээлэнгийн ажилтануудын санаачлагаар буддын шашны ном, зохиолуудыг цуглуулах ажил зохион байгуулсны ачаар, дацангуудын зарим бүтээлүүд хадгалагдсан байна. 1927 онд Дамбинов, Бородин нар болон бусад хүмүүс зарим дацангийн болон хувь хүмүүсийн шашны номуудыг хүрээлэнгийн номын санд өгчээ. 1928 онд Хоца Намсараев монгол хэл дээр бичсэн 108 боть Ганжуурыг Чисаны дацангаас авчирсан. 1930 онд Генин-Дарма Нацов Эгэтийн дацангаас 700 боть төрөл бүрийн ном олсон. Мөн тэрбээр хамба лам Иролтгевын 1000 гаруй боть номыг номын санд авчиржээ. 1930 онд Алаараас Ганжуурыг авчирсан. Гэвч номын цуглуулга тууштай явагдаагүй. Ихэнх номууд их муу байдалтай байсан.

Ийнхүү буриад дацангууд маш том номын сангуудын үүрэг гүйцэтгэж, буриадын ард түмний түүхэн-соёлын өвийн чухал төв байжээ. Харамсалтай нь 1917 оны хувьсгалын дараа эдгээр үнэт дурсгалт зүйлүүдийг зэрлэгээр устгасан байна. Үнэлж баршгүй манай үндэсний баялагийг бид нар хайрлаж, яваандаа шинжлэх ухааны эргэлтэнд оруулж, өргөн олондоо хүргэж өгөх явдал билээ.

*Орчуулсан М.Татьяна*

## **АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ**

1. Кара Дьердь. Книги монгольских кочевников. М., 1972.
2. Ц.Шүгэр. Монгол модон барын ном. Улаанбаатар, 1991.3-р тал.
3. Дацан - “сүм хийд” гэсэн утгатай буриад үг. /орч./
4. БН Буриад Улс 1923 онд анх байгуулагдснаас хойш 1958 он хүртэл хуучин нэрээрээ Буриад-Монгол АССР гэж нэрлэгдэж байжээ./ орч./
5. Страницы из жизни Агвана Доржиева. Архивные документы. Улан-Удэ, 1993.
6. Дашиев Д. Буряад номой түүхээхээ. Гуламта. 1991.20 февраля.
7. дурьдсан ном.
8. дурьдсан ном.
9. Страницы из жизни Агвана Доржиева. Архивные документы. Улан-Удэ, 1993.стр.57.